

## ӨГҮҮЛЭЛ

**Турк сургуулиуд: Төв Азийн орнууд ба  
Монголын жишээ****Чулуунбаатарын Цэрэннадмид**

*ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Гуравдагч хөрш орон судлалын салбарын Эрдэм шинжилгээний ажилтан, доктор Ph.D  
tserennadmidch@mas.ac.mn*

*Хураангуй: 2016 оны 7 дугаар сард гарсан төрийн эрх мэдлийг цэргийн хүчээр авах оролдлого нуран унасны дараагаар БНТУ-ын ерөнхийлөгч Р.Т.Эрдоан Евроазийн бүс нутгийн улс орны удирдагч нарт хандан шашны номлогч Ф.Гюлений байгуулсан сургуулиудыг яаралтай хаахыг уриалж эхэлжээ. Энэ үйл явдлын дараагаар Туркийн засгийн газар Гюлений үзэл санааг дэмжигч, тус улсад ажиллаж, амьдарч буй иргэд, төрийн албан хаагчид, их дээд сургуулийн багш нарыг баривчлах, цагдан хорих, албан тушаалаас нь халах зэрэг арга хэмжээ авлаа. Ф.Гюлений ФЕТО байгууллагыг террорист байгууллага хэмээн БНТУ засгийн газар албан ёсоор зарлав.*

*Энэхүү өгүүлэлд 1970-аад оны эхэн үеэс үүсгэн байгуулагдаж, зөвхөн Турк улс төдийгүй дэлхийн олон улс оронд салбараа нээн, үйл ажиллагаагаа тэлэн, хөгжиж эхэлсэн Гюлений гэх тодотголтой боловсролын байгуулагууд Төв Азийн орнууд болон Монгол улсад хэрхэн үүсч, хөгжсөн талаар товч дурдаж, эдгээр сургуулийн асуудал, Монгол, Турк хоёр орны харилцаанд үзүүлж буй нөлөө, цаашидын хандлага, шийдлийн талаар цэгцтэй мэдээлэл өгөхийг зорьлоо.*

**Түлхүүр үгс:** Турк сургуулиуд, “Хизмет” хөдөлгөөн, төрийн эргэлт, зөөлөн хүч.

**Турк сургууль буюу Ф.Гюлений боловсролын институтын үүсэл хөгжил**

1970-аад оны дунд үеэс Исламын шашны номлогч Фетуллах Гюлен болон түүний үзэл санааг дэмжигчид Туркийн шашин, соёл, нийгэм, улс төрийн амьдралд нөлөөтэй болж

эхэлсэн бөгөөд 1982 онд Турк улсад анхны сургуулиа байгуулж байжээ. Хизмет хөдөлгөөнийг үүсгэн байгуулагч Ф.Гюлен нь исламын шашны суннит урсгалыг баримтлагч

Received: 21 June, 2020; Accepted: 9 November, 2020

<https://orcid.org/0000-0001-5892-4677>

© The Author(s) 2020.

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

бөгөөд 1990-ээд онд Турк улсад сүм хийд хэт олон байгаа нь ард иргэдэд төдийлөн шаардлагагүй, сургуулиудын тоог нэмэх шаардлагатай гэж үзэн, уг шийдвэрийн дагуу сургуулиудын сүлжээ байгуулж, Хизмет хөдөлгөөний үйл ажиллагааг улам өргөжүүлэх болсон байна. Хизмет хөдөлгөөний гол номлол нь хүмүүсийн төлөө сэтгэл гарган зүтгэх, исламын шашинт улс түмнүүдийн сайн сайхны төлөө үйлчлэх тухай бөгөөд анх гарч ирэхдээ залуу үеийн боловсрол, ёс суртахууны хүмүүжлийн асуудалд анхаарал хандуулж ажилласнаар олон нийтэд танигдаж, нэр хүндтэй болж байжээ. Ийнхүү 1980-1990 оны дунд үе хүртэл дотооддоо сургууль байгуулах, шашны ухуулга, сурталчилгаа хийх зэрэг үйл ажиллагаа явуулж байгаад 1990-ээд оноос эхлэн олон улсад салбар сургууль, боловсролын байгууллагуудыг байгуулж эхэлжээ.

Өнөөдөр дэлхийн 170 гаруй улсад Ф.Гюлений санхүүжилттэй 3000 гаруй сургууль байдаг. Сургууль байгуулсан аль ч улс оронд шашны бус – иргэний хувийн боловсролын байгууллага гэсэн статустайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Сургууль бүр тухайн орны сургалтын, стандартын дагуу хөтөлбөр хэрэгжүүлдэг, хичээлийн дийлэнх хэсгийг англи хэлээр заадаг. Санхүүгийн дэмжлэг шаардлагатай, сурлага сайтай сурагчдад тэтгэлэг олгох, сургалтын төлбөрөөс хөнгөлөх зэрэг арга хэмжээ авдаг.

Гэхдээ зарим судлаач Гюлений сургуулиуд бол шинжлэх ухаан, боловсролд хөрөнгө оруулах замаар исламын шашны нэгдмэл байдал, эв нэгдэл, зохицлыг Турк болон дэлхийн бусад улс оронд бий болгох, түгээн дэлгэрүүлэх далд зорилгыг агуулдаг<sup>1</sup> гэсэн дүгнэлт тайлбарыг хийдэг юм.

Мөн судлаачдын ажигласнаар эдгээр сургуульд исламын шашны үзэл санааг шууд түгээн дэлгэрүүлсэн, сурталчилсан үйл ажиллагаа ил байдлаар явагддаггүй ч багшилж буй хүмүүсийн зан байдал, уншдаг ном, ашигладаг мэдээллийн хэрэгсэл зэргээс харахад багш нар нь исламын шашинт хүмүүс, явуулж буй үйл ажиллагаа нь шашныг дэлгэрүүлэх шинжтэй<sup>2</sup> байдаг ажээ.

Ф.Гюлений сургуулиуд ийнхүү 1970-1990-ээд оны хооронд дотооддоо үйл ажиллагаа явуулж, хүрээгээ тэлж, хүчирхэгжиж байсан бол 1990-ээд оны дунд үеэс буюу ЗХУ задран унасны дараа түүний бүрэлдэхүүнд байсан, шинээр тусгаар тогтносон Төв Азийн бүгд найрамдах улсууд, Кавказын орнууд тэр дундаа Азербайджан, Гүрж улсуудад сургууль нээх замаар үйл ажиллагаагаа олон улсад эрчимтэй өргөжүүлж эхэлсэн<sup>3</sup> бөгөөд 2002 онд Туркийн “Шударга ёс, хөгжлийн нам” засгийн эрхэнд гарснаас хойш, хүрээгээ тэлж эхэлсэн нь Английн хэвлэлийн эх сурвалж, баримт мэдээллээр дэлхийн 170 гаруй оронд 3000 орчим сургууль, сургалтын төв<sup>4</sup> байдаг ажээ.

1 Bayram Balci „Islam Missionary in Central Asia – Gulen schools“, 2005, Istanbul

2 Salih Cingillioglu “The Gulen Movement: Transformative social change”, page 97, Sarajevo, Bosnia and Herzegovina, 2017.

3 Bayram Balci What Future For the Fethullah Gülen Movement in Central Asia and the Caucasus? July 02, 2014 - Analytical Article - Central Asia-Caucasus Analyst – Biweekly Briefing

4 <https://www.bbc.com/turkce/haberler-dunya-37446729>

Учир нь тэр үед Турк улсын одоогийн ерөнхийлөгч Рэжэп Тайп Эрдоан ба сургууль санаачлагч Фэттуллах Гюлен нарын хооронд үзэл суртлын зөрчилдөөн харьцангуй бага байв. Тэд улс төрийн нэг намд харьяалагдаж байсны зэрэгцээ Шударга ёс, хөгжлийн намын төлөө, санхүүгийн хувьд дэмжих үйл ажиллагаанд хамтран зүтгэж байсан<sup>5</sup> гэж улс төр

судлаачид үздэг.

2004, 2009 онуудад Шударга ёс, хөгжлийн намын улс төрчид болох Абдуллах Гюл, Мэвлут Чавушоглу нар Төв Ази, Африкийн орнуудаар, тухайлбал Найроби зэрэг Африкийн орнуудад айчлах үедээ Турк сургуулийн нээлтийн арга хэмжээнд оролцож, үйл ажиллагааг дэмжиж буйгаа харуулж байсан юм.

### Төв Азийн орнууд дахь турк сургуулиуд

Гюлен сургуулиа нээсэн 170 гаруй улсын дийлэнх олонх нь Төв Ази, Африк, Кавказын орнуудад байдаг бөгөөд Төв Азийн Бүгд Найрамдах улсуудад ЗХУ задарсанаас хойш буюу 1990-ээд оны эхэн үед анх нэвтэрсэн бол Африкийн орнуудад 2000 оны дунд үеэс нэвтэрч эхэлжээ. Тухайлбал, 2011-2012 онд Шударга ёс, хөгжлийн намын засгийн газрын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болох Африкийн орнуудтай харилцаагаа өргөтгөх, нөлөөгөө тэлэх бодлогоо Гюлений сургуулиудаар дамжуулан хэрэгжүүлж байжээ. Африкийн орнуудын нийслэл хотуудад сургууль нээх, Туркиш Эйрлансын шууд нислэг бий болгох, эдгээр улсад суух Элчин сайдын яамны ажилтнуудаа Гюлений ажиллах хүчнээс томилох зэрэг үйл ажиллагаа явуулж байжээ.<sup>6</sup>

1990-ээд оны эхэн үеийн Бүгд Найрамдах Турк улсын гадаад бодлогод онцгой байр суурь эзэлж эхэлсэн төв Азийн орнууд, тэр дундаа Монгол

Улстай харилцах Туркийн зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх нэг хэлбэр, арга хэрэгсэл хэмээн ойлгогдож байсан эдгээр сургуулиудыг исламын шашинт улсуудад шашны үзлийг түгээн дэлгэрүүлэх, тэр дундаа төв Азийн бүс нутагт Туркийн нөлөөг тэлэх бодлогын нэг хүчин зүйл гэж зарим судлаачид харж байсан юм.<sup>7</sup>

2014 онд Олон улсын энх тайвны Карнегийн сангаас гаргасан нийтлэлд Ф.Гюлений үзэл суртлыг түгээн дэлгэрүүлэгч сургууль, боловсролын байгууллагууд Казакстан улсад нийт 30 орчим, Киргиз улсад 10 гаран сургууль өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна гэжээ.

Харин Тажикистан улс 2013 оны дунд үеэс эхлэн турк сургуулиудыг хааж эхэлсэн бол Туркменистан 2010 оны эхэн үеэс хааж эхэлжээ. Узбекистан улсын хувьд харьцангуй эрт буюу 2001 оноос эхлэн зарим сургуулийг хааж, заримыг нь улсын сургууль болгон өөрчилсөн байдаг.

5 <http://www.cacianalyst.org/publications/analytical-articles/item/13006-what-future-for-the-fethullah-g%C3%BClen-movement-in-central-asia-and-the-caucasus?.html>

6 Asli Aydintasbas, "The Good, the Bad and the Gulenists: The role of the Gulenist Movement in Turkey's Coup Attempt", page 3, European Council of Foreign Affairs, ECFR/188

7 Bayram Balci „Islam Missionary in Central Asia – Gulen schools“, 2005, Istanbul

2018 оны байдлаар Бүгд Найрамдах Киргиз улсын хувьд Гюлений санхүүжилтээр байгуулагдсан гэж Туркийн засгийн газраас үзэж буй нийт 21 сургалтын байгууллагад 12,500 оюутан суралцдаг бөгөөд эдгээр сургуулиуд нь ерөнхий боловсролын буюу ахлах сургууль, их сургууль, хэлний төв гэх мэт олон төрөл, хэлбэрээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг ажээ. 2016 онд Турк улсад болсон төрийн эргэлт хийх оролдлогын дараагаар Турк улсын зүгээс тус улсын засгийн газарт хандан эдгээр сургуулиудыг хаах хүсэлт тавьсан боловч тухайн үеийн Киргиз улсын ерөнхийлөгч А.Атанбаев энэ хүсэлтийг хүлээн аваагүй юм.

Тажикстан улсын хувьд 2016 оны

байдлаар, Гюлений санхүүжилтээр байгуулагдсан гэж Туркийн засгийн газраас үзэж буй нийт 6 сургууль 4 өөр мужид үйл ажиллагаа явуулж байсан юм. Харин Турк улсын зүгээс тус улсын Засгийн газарт хандан эдгээр сургуулиудыг хаах, удирдлага, менежментийг өөрчлөх, Туркийн засгийн газарт хүлээлгэн өгөх хүсэлт тавьсаныг судлан үзэж, сургуулийн удирдлагыг Засгийн газарт шилжүүлж, нэр, бүтэц зэргийг өөрчилжээ.

Гюлений сургуулиуд эдгээр улсад зөвхөн ахлах, дунд сургууль хэлбэрээр бус, их сургууль, шашин-соёлын төв, их сургуульд бэлтгэх курс, хэлний дамжаа зэрэг олон хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байна.

### **Турк дахь дотоод зөрчил, Засгийн газрын байр суурь**

Ийнхүү дэлхийн 170 гаран улсад сургууль байгуулж, эдгээр сургуулиудын үйл ажиллагааг дэмжих хандлага дотоодод нэмэгдэж эхэлсэн цаг үетэй зэрэгцээд 2000-аад оны сүүл үеэс Р.Т.Эрдоаны удирдсан – Шударга ёс хөгжлийн нам хүчирхэгжих болов. Өөрөөр хэлбэл, Ф.Гюлений хөдөлгөөн, холбооноос дэмжлэг авах шаардлагагүй болж, ард иргэдийн дунд Турк улс нэг намын улс боллоо гэсэн шүүмжлэл газар авч эхэлсэн бөгөөд үүнийг дагаад Гюлен-Эрдоан нарын хооронд нуугдмал байсан зөрчил ил гарч, улам хурцдаж эхэлжээ.<sup>8</sup>

Ф.Гюленийг дэмжигчид, түүний байгуулсан банк, санхүү, барилга,

хөрөнгө оруулалтын байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, шашин, соёлын болон боловсролын байгууллагууд ийнхүү хүчээ авч, тэдний төлөөлөл бүхий нууц сүлжээ Туркийн засгийн газарт, тэр дундаа шүүх, цагдаа зэрэг хүчний байгууллагуудад бий болж эхэлсэн гэх мэдээлэл Туркийн Дотоод хэргийн яам болон бусад холбогдох албаны сурвалжаар баталгаажигч эхлэв. Жишээлбэл, 2013 оны эцэс гэхэд Туркийн засаг захиргааны нийт 81 мужаас 77 мужийн прокурор, цагдаагийн байгууллагын удирдлага Гюлений үзэл санааг дэмжигчид болсон байв.<sup>9</sup> Улмаар 2016 оны 7

8 Asli Aydinbas, “The Good, the Bad and the Gulenists: The role of the Gulenist Movement in Turkey’s Coup Attempt” page 2, European Council of Foreign Affairs, ECFR/188

9 “Efsan Ala: 81 ilin emniyet müdüründen 74’ü FETÖ’cü çıktı”, HaberTurk, 19 August 2016, available

дугаар сарын 15-ны өдрийн цэргийн эргэлт хийх оролдлогын дараагаар дээрх зөрчил дээд цэгтээ хүрч БНТУ-ын Засгийн газрын зүгээс Ф.Гюлентэй холбоотой бүх байгууллага, сургууль боловсролын байгууллагуудыг хаах, Турк сургууль нэрээр гадны улс орнуудад үйл ажиллагаа явуулж буй сургуулиудын үйл ажиллагааг зогсоох уриалга гаргаж эхэлсэн юм. Энэхүү уриалга, шаардлагын дараа Азербайжан, Сомалийн Холбооны Бүгд Найрамдах улс зэрэг зарим улс зөвшөөрч, зарим улс болгоомжилж байсан бол Киргиз, Индонез, Нигер, Кени зэрэг улс орон тус шаардлагыг хүлээж аваагүй юм.<sup>10</sup> Эдгээр улс орон Туркийн Засгийн газраас тавьж буй тус шаардлагыг хүлээж аваагүй гол шалтгаанаа улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож, боловсролыг улс төрийн хэрэгсэл болгохыг үл зөвшөөрч байгаагаар тайлбарлажээ.

Турк улс чухам яагаад гадны улсуудад байгаа Турк сургуулиудыг хаах хэрэгтэй гэж үзэж энэхүү шаардлагыг бусад улс оронд тавих болсон нь нухацтай судлах асуудал юм. Одоогийн байдлаар Туркийн Засгийн газрын албан ёсны байр суурийг үндэслэн зарим нэг дүгнэлт хийж болох байна.

2016 оны 9 сарын 28-ны өдөр CNN Turk телевизийн сувагт өгсөн ярилцлагадаа Бүгд Найрамдах Турк улсын Гадаад хэргийн сайд Мэвлүт Чавушоглу “Эдгээр сургуулийг төгссөн

төгсөгчид Ф.Гюлений үзэл санааг дэмжигчид болох магадлалтай, тухайн улс оронд хувьсгалт тэмцэл өдөөх, нийгмийг турхирах, эмх замбараагүй байдал үүсгэх магадлалтай” гэж хэлсэн байдаг.

Дээрх шаардлагын хариу болгож Төв Ази, Африкийн орнууд янз бүрийн арга хэмжээ авсан. Тухайлбал Узбекистан, Туркменистан, Тажикистан зэрэг улсууд турк сургуулиудыг хаах, эсвэл өөрийн улсын сургууль болгох нь зөв, эс бөгөөс шашны хэт үзэл дэлгэрэх, туркийн нөлөө нэмэгдэх, цаашлаад улс орны дотоод байдалд сөргөөр нөлөөлөх, хоёр талын харилцаанд сэв суух зэрэг эрсдэл байгаа учир хаах нь зүйтэй гэж үзээд хаах, өөрийн улсын сургууль болгох зэрэг арга хэмжээ авчээ.

Харин зарим улс орны удирдагчид, тухайлбал Киргиз улсын ерөнхийлөгч асан А.Атанбаев<sup>11</sup> шаардлагыг хүлээж аваагүй гол шалтгаан нь улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож байна, боловсролыг улс төр хийх хэрэгсэл болгон ашиглаж байна, эдгээр сургуулиуд манай улсын хууль дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа, энэ сургуульд ажиллаж буй багш ажилчид хууль, шүүхийн байгууллагаар буруутай гэдэг нь нотлогдоогүй байхад бид ямар нэг арга хэмжээ авах, халах, сургуулиудыг хаах боломжгүй гэсэн мэдэгдлүүдийг хийсэн юм.

Ер нь эдгээр сургуулийн багш,

---

at <http://www.haberturk.com/gundem/haber/1284610-efkan-ala-81-ilinemniyet-mudurunden-74u-fetocucikti>

10 <https://www.bbc.com/turkce/haberler-turkiye-36950705>

11 Киргиз улсын ерөнхийлөгч А.Атанбаевийн 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдөр хийсэн хэвлэлийн бага хурал.

суралцагсад тухайн улсдаа бослого, тэмцэл өдөөж, аюул учруулах магадлалтай гэсэн хардлага нь төдийлөн бодитой, логик гаргалгаа биш юм гэж Казахстан, Киргиз зэрэг орны удирдагчид, судлаачид үздэг юм байна. Учир нь Гюлений сургуулиудын зохион байгуулалт улс орон бүрт харилцан адилгүй.

### Монгол дахь турк сургууль ба хоёр орны Засгийн газрын хандлага

Монгол Улсад турк, монгол иргэдийн хамтран байгуулсан таван ерөнхий боловсролын сургууль бүртгэлтэй. Анх 1994 онд Монгол, Турк улсын иргэд болох 5-6 хүн хөрөнгө оруулж, энэхүү ерөнхий боловсролын сургууль байгуулсан байдаг. Одоогийн удирдах зөвлөлийн гол бүрэлдэхүүнд үүсгэн байгуулагчдын төлөөлөл бий. Анх МУИС-ийн дэргэдэх байгалийн ухааны лицей сургууль нэртэйгээр байгуулагдаж байсан сургууль 1997 онд бие даасан Монгол, Туркийн хамтарсан ерөнхий боловсролын сургууль болж гарсан. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хувийн дунд сургуулийг хэрхэн үүсгэн байгуулдаг зарчмаар байгуулсан, Монголын болон Туркийн хувь иргэдийн хөрөнгө оруулалттай сургууль юм.

1997 онд анхны төгсөгчөө гаргаснаас хойш 2018 оны хүртэл 1299 сурагч төгсөж, тэдгээрийн 45 орчим хувь нь барууны их дээд сургуульд

Хамгийн гол нь Турк дэх Гюлений хөдөлгөөнийхөн цагдаа, шүүх гэх мэт хүчний байгууллагад нууц сүлжээтэй болсон байдаг бол бусад улс оронд тийм сүлжээ байгуулах хэмжээнд хүрч, хүч нөлөөтэй болж чадаагүй гэсэн судлаачдын дүгнэлт бодитой байх магадлал өндөр юм.

амжилттай элсэн, тэтгэлэгтэй суралцаж байгаа юм.<sup>13</sup> Монгол Улсын хэмжээнд нийт 5 ерөнхий боловсролын сургууль байдаг бөгөөд эдгээрээс Улаанбаатар хотод 2 сургууль, Дархан-Уул, Орхон, Баян-Өлгий аймаг тус бүрт 1 ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаа явуулж байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Турк сургуулиудын нэг жилийн сургалтын төлбөр 2.5-3 сая төгрөг, Улаанбаатар хотын хоёр сургуулийн төлбөр 4.8-7.5 сая төгрөг байдаг ажээ.<sup>14</sup> 2019 – 2020 оны хичээлийн жилд Монгол дахь Туркийн хөрөнгө оруулалттай ерөнхий боловсролын 5 сургуульд 2000 гаруй хүүхэд суралцаж байна.<sup>15</sup>

Турк улсад 2016 оны 7 сард болсон төрийн эргэлт хийх оролдлогын дараа 8 сарын эхээр Туркийн Гадаад хэргийн сайд Мэвлут Чавушоглу Монгол Улсын Гадаад харилцааны сайдтай утсаар ярьж, Турк улсад бий болсон эмх замбараагүй байдал, Гюлений хөдөлгөөний талаар цаг үеийн

12 Bayram Balci, <https://www.bbc.com/turkce/haberler-turkiye-36950705>

13 <https://empathy.edu.mn/en/alumni/>

14 “Улаанбаатар-Эмпати” сургуулийн захирал Д.Ганбаатар, “Турк сургууль Монголд хаагдахгүй” “Өдрийн сонин”, 2016 оны 11 сарын 15.

15 <http://empathy.edu.mn/directors-message/>

мэдээлэл өгсөн байдаг.

Харин 2016 оны 10 сард Турк улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Мурат Карагөз, Гюлений хөдөлгөөнийг дэмжигчдийн учруулж болох аюул, эрсдлийн талаар Монголын холбогдох байгууллагуудад мэдээлж, цаашид Монголын ард түмэнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан энэ талаар байнга мэдээлж байна хэмээн мэдэгдсэн юм.

2016 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Туркийн Боловсролын яамны төрийн нарийн бичгийн дарга Юусуф Текин тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчилж, Турк сургууль нэрийн дор үйл ажиллагаа явуулж буй сургуулиудыг хаахыг хүсэлт болгосон юм.

2017 оны 3 сард БНТУ-аас шинээр томилогдсон элчин сайд Мехмет Язал Турк сургуулиудын удирдлагыг солих, Туркийн Засгийн газарт шилжүүлж, сургалтын үйл ажиллагаа, сурагчдын боловсрол эзэмших эрхэд ямар нэг өөрчлөлт, сөрөг нөлөөгүйгээр үргэлжлүүлэх нь илүү зохистой юм гэсэн мэдэгдлийг мөн хийсэн байдаг.

2018 оны 2 сард Туркийн ЭСЯ-аас хийсэн мэдэгдэлд, Монгол дахь турк сургуулийг төгсөгчдийн дипломыг зөвхөн Туркийн их, дээд сургуулиудад л хүлээн зөвшөөрөхгүй, дэлхийн бусад улс оронд зөвшөөрнө гэсэн тайлбарыг хийсэн байдаг.

Манай засгийн газрын зүгээс дээрх хүсэлтийг судлан үзээд, Гадаад Харилцааны Яамаар дамжуулан хариу тайлбар хүргүүлсэн байдаг. Гадаад, монгол иргэн хувь нийлүүлж,

байгуулсан сургуулиуд хууль бус үйл ажиллагаа хийгээгүй л бол хаах хууль эрх зүйн үндэс байхгүй. Иргэний хувийн өмчөөр байгуулсан сургууль учир одоогоор хаах ямар ч хууль эрх зүйн үндэс байхгүй гэсэн тайлбар хийсэн байна. Харин Турк улсын хувьд, хоёр талын харилцааг хэвийн хэмжээнд барихын тулд эхлээд энэ асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй гэсэн шаардлагыг байнга тавьдаг.

Ийнхүү дэлхийн олон оронд үйл ажиллагаа явуулж байсан Турк сургуулиудад нэр, бүтэц, менежментийн хувьд өөрчлөлт хийх, Туркийн засгийн газрын хүлээн зөвшөөрсөн субъектэд эрх шилжүүлэх зэрэг хүсэлтийг Бүгд Найрамдах Турк улсын засгийн газар улс орнуудад удаа дараа албан ёсоор хүсэлт болгосоор байгаа юм. Үүний зэрэгцээ Туркийн боловсролыг дэлхийд таниулах зорилго, алсын хараатайгаар 2016 оны 6 дугаар сард байгуулагдаж байсан Маариф Сангаар дамжуулан гадаад улс орнуудад боловсролын үйл ажиллагаа явуулж эхэлжээ. Тус сангийн эцсийн шийдвэр гаргах эрх бүхий 12 гишүүн байдаг бөгөөд тэдгээрийн 4 гишүүнийг Турк улсын ерөнхийлөгч, 3 гишүүнийг Сайд нарын зөвлөлөөс томилдог бол Туркийн Үндэсний Боловсролын яамнаас 2, Гадаад харилцааны яамнаас 1, Сангийн яамнаас 1, Дээд боловсролын зөвлөлөөс 1 төлөөлөгч байдаг ажээ.<sup>16</sup> Энэхүү сангийн үйл ажиллагаагаар дамжуулан Турк улсын засгийн газар гадаад улс оронд үйл ажиллагаагаа явуулж байсан Ф.Гюлений сургуулиудыг өөрийн

16 <https://turkiyemaarif.org/uploads/TanitimKatalogu2018.pdf>

хяналтандаа авах зорилготой гэж судлаачид үзэж байна.<sup>17</sup>

Бүгд Найрамдах Турк улсын шадар сайд Хакан Чавушоглу 2018 оны 3 дугаар сард Монгол улсад албан ёсны айлчлал хийж, шадар сайд Ө.Энхтүвшинтэй уулзах үеэр Монгол Улсын засгийн газар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Турк сургуулиудыг Туркийн боловсролыг гадаад оронд албан ёсоор төлөөлж буй Маариф санд хүлээлгэн өгнө гэдэгт найдаж байна гэдгээ илэрхийлж байжээ.<sup>18</sup>

2019 оны 1 дүгээр сард Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй таван Турк сургуулийн удирдлага, менежментэд өөрчлөлт хийж, Германы хөрөнгө оруулалттай компанид шилжсэн шийдвэр гарчээ.

2019 оны 6 дугаар сард “Эмпати”

сургуулиудыг эзэмшдэг Германы “Ewe Empathy Worldwide Education” компанийн захирал Йозеф Функе 2 жилийн өмнө эдгээр сургуулиудад хөрөнгө оруулалт хийж Монгол, Германы хамтарсан сургууль болсон бөгөөд өнгөрсөн хоёр жилд зарим томоохон өөрчлөлтүүд хийгдэж, сургалтын чанар улам сайжирч, Кэмбрижийн хөтөлбөрөөр сургалт явуулах шаардлагыг хангасан тухай мэдээлсэн байдаг. Ийнхүү эдгээр сургууль нь Герман улсын иргэний хөрөнгө оруулалттай Монгол-Германы хамтарсан Эмпати сургууль нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Улаанбаатар дахь ХБНГУ-ын ЭСЯ-ны мэдээлснээр Холбооны Засгийн газар ч, Германы бусад төрийн байгууллага ч эдгээр сургуульд хувь эзэмшдэггүй, ямар ч оролцоогүй байдаг аж.

### Дүгнэлт

1995 онд Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ, 2004 онд Иж бүрэн түншлэлийн гэрээг тус бүр байгуулж, улс төр, нийгэм, хүмүүнлэгийн салбарт идэвхитэй харилцаатай байгаа Монгол, Турк хоёр орны харилцаанд Турк сургуулиудын асуудал тодорхой хэмжээнд хүндрэл учруулах эрсдэл байсаар байна.

Хизмет хөдөлгөөн, Ф.Гюлений талаар тусгайлан судалгаа хийдэг судлаачдын дийлэнх нь уг хөдөлгөөн чухам ямар зорилготой Төв Ази, Африк, Кавказын бүс нутгийн улс орнуудад сургууль нээж эхэлсэн, исламын шашны нэг урсгал болох

нуржу үзлийг даган дэлгэрүүлэгч Алтан үеийн номлогчдийг бэлтгэх зорилготой байв уу, эсвэл эдгээр улсуудад Туркийн нөлөөг тэлэх, Турк болгох бодлогын нэг арга хэрэгсэл байв уу гэдгийг судлахыг оролдсон байна.

Эдгээр судлаачдын хийсэн дүгнэлтээс харахад, Гюлений сургуулиуд 1990-ээд оны эхэн үеэс 2010 оны дунд хүртэл боловсрол, соёл, нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах замаар Туркийн зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх нэг хэлбэр, илэрхийлэл байсан гэсэн байгаа юм. Энэ дүгнэлтийг харьцангуй бодитой дүгнэлт гэж судлаач миний бие үзэж байна.

17 [http://www.xinhuanet.com/english/2018-03/22/c\\_137057359.htm](http://www.xinhuanet.com/english/2018-03/22/c_137057359.htm)

18 <https://www.aa.com.tr/en/asia-pacific/turkey-calls-on-mongolia-to-hand-over-feto-schools/1095403>



Европын Холбоонд элсэх замд яваа Турк улсын хувьд 1990-ээд оноос хойш, шинээр тусгаар тогтносон турк хэлтэн Бүгд Найрамдах улсуудад нөлөөгөө тогтоох стратегийн зорилтыг давхар агуулсаар байгаа юм. Ф.Гюлений сургуулиудын хувьд энэхүү зорилтыг биелүүлэх гол зууч, хөтөчийн үүргийг тодорхой хугацаанд гүйцэтгэж байсан гэж үзэж болох юм.

Гэхдээ энэ нөхцөл байдал 2012 оноос эхлэн Турк улсын хууль, эрх зүйн орчны шинэчлэл, дотоод улс төрийн амьдралд гарсан өөрчлөлт, улам бүр нэмэгдэх болсон улс төрийн хүчнүүдийн хоорондын зөрчил, тэмцлийн нөлөөгөөр өөрчлөгдөж, тус улсын олон улстай харилцах харилцаа, хамтын ажиллагаанд ч хүндрэл, бэрхшээл бий болоход хүргэж байна.

Бүгд найрамдах Турк улсын зүгээс Турк сургуулиудын үйл ажиллагааг

хаах хүсэлтээ зөвхөн Монгол Улс бус Төв Ази, Африкийн олон улсад хүргүүлсэн байдаг бөгөөд эдгээр сургуулиудын үйл ажиллагааг хаагаагүй нөхцөлд алан хядах үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг санхүүжүүлэгч мэт ойлгогдоно гэсэн Турк улсын төр, засгийн албан ёсны байр суурийг энд анхаарч үзэх ёстой юм.

Үүний тулд иж бүрэн түншлэлийн түвшинд байгаа хоёр орны харилцаанд сэв суулгахгүй, улс орны дотоод хэрэгтээ хөндлөнгөөс оролцуулахгүй байх үндсэн зарчмын хүрээнд асуудлыг шийдвэрлэх, монгол иргэдийн сурч, боловсрох эрхийг хамгаалах, хаасан нөхцөлд сурч боловсрох илүү таатай орчин, сонголтыг бий болгоход тусгайлан анхаарах зэрэг олон хүчин зүйлийг орхигдуулахгүй байх ёстой.

**Ашигласан материал:**

1. Bayram Balci „Islam Missionary in Central Asia – Gulen schools, 2005, Istanbul
2. Christopher L. Miller „The Gulen Hizmet Movement: Circumspect Activism in Faith-Based Reform“ Cambridge Scholars Publishing, 2012
3. Үндэсний тойм сэтгүүл, 2013 оны № 4
4. Засгийн газрын мэдээ сонин, 2018 оны 3 дугаар сарын 20-ны дугаар
5. БНТУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын албан мэдэгдэл Өнөөдөр сонин, 2017 оны 3 сарын 10
6. [www.mfa.gov.tr](http://www.mfa.gov.tr) – БНТУ-ын Гадаад Харилцааны Яамны цахим хуудас
7. [http://meb.gov.tr/popup/14\\_07\\_2017/index.html](http://meb.gov.tr/popup/14_07_2017/index.html) – БНТУ-ын Үндэсний Боловсролын Яамны цахим хуудас
8. Bayram Balci, <https://www.bbc.com/turkce/haberler-turkiye-36950705>
9. <https://empathy.edu.mn/en/alumni/>
10. “Улаанбаатар-Эмпати” сургуулийн захирал Д.Ганбаатар, “Турк сургууль Монголд хаагдахгүй” “Өдрийн сонин”-д өгсөн ярилцлага, 2016 оны 11 сарын 15.
11. <http://empathy.edu.mn/directors-message/>
12. <https://www.bbc.com/turkce/haberler-turkiye-36950705>
13. Киргиз улсын ерөнхийлөгч А.Атанбаевийн 2016 оны 12 сарын 1-ны өдөр хийсэн хэвлэлийн бага хурал..
14. Asli Aydintasbas., “The Good, the Bad and the Gulenists: The role of the Gulenist Movement in Turkey’s Coup Attempt” Page 2, European Council of Foreign Affairs., ECFR/188
15. “Efkan Ala: 81 ilin emniyet mьdььnden 74’ь FETЦ’сь zikti”, HaberTurk, 19 August 2016, available at <http://www.haberturk.com/gundem/haber/1284610-efkan-ala-81-ilinemniyet-mudurunden-74u-fetocu-cikti>
16. <https://www.bbc.com/turkce/haberler-dunya-37446729>
17. <http://www.cacianalyst.org/publications/analytical-articles/item/13006-what-future-for-the-fethullah-g%C3%BClen-movement-in-central-asia-and-the-caucasus?.html>
18. Salih Cingillioglu “The Gulen Movement: Transformative social change”., page 97, Sarajevo, Bosnia and Herzegovina, 2017.
19. Bayram Balci “What Future for the Fethullah Gьlen Movement in Central Asia and the Caucasus? July 02, 2014 - Analytical Article - Central Asia-Caucasus Analyst – Biweekly Briefing<https://thediplomat.com/2015/08/tajikistan-turkey-and-the-gulen-movement/> *Samantha Brletich*

## **Turkish schools around the world: Examples of Central Asian countries and Mongolia**

***Tserennadmid Chuluunbaatar***

*Ph.D, Institute of International Affairs, Mongolian Academy of Sciences,  
Ulaanbaatar, Mongolia, tserennadmidch@mas.ac.mn*

***Abstract:*** *As part of a wide-ranging clampdown in the aftermath of the failed July coup, Turkish President Recep Tayyip Erdoğan’s administration has urged countries in Eurasia to shut down schools associated with Fethullah Gülen, Islamic Cleric. Following this, Gülen’s supporters in Turkey have been arrested, fired from their state jobs. The Turkish government has also classified Gülen’s organization as a terrorist group. This article attempts to explore the origins of the Turkish schools supported by the Gulenist movement that was established in early 1970s in Turkey, its expansion in the country and other countries, in central Asian republics and Mongolia. It also aims to provide summarized information to the reader about the establishment and activities of Turkish schools in Mongolia, and to highlight the recent development and potential impact of communications and bilateral relations between the Republic of Turkey and Mongolia on this matter.*

***Key words:*** *Turkish schools, “Hizmet” movement, military coup, cooperation, soft power.*

<i>The day of submission:</i>	<i>2020.7.21</i>
<i>Completion of review:</i>	<i>2020.10.28</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2020.11.9</i>